



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 04 сарын 28-дээр

Дугаар 1136

Мандалговь

Г Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөл  
шинэчлэн байгуулах тухай Т

Монгол Улсын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх заалт, Монгол улсын Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дах заалт, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Аймгийн хөдөлмөр эрхлэлтийн зөвлөлийт дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Зөвлөлийн дэд дарга: Аймгийн Засаг даргын орлогч  
Гишүүд: Нийгмийн бодлогын Хэлтсийн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал хариуцсан мэргэжилтэн  
Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга  
Аймгийн Үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга  
Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого  
төлөвлөлтийн хэлтсийн дарга  
Аймгийн ажил олгогч эздийн холбооны дарга  
Мэргэжлийн боловсрол сургалтын Говийн бусийн арга зүйн төвийн менежер  
MYXAYT-ийн Дундговь аймаг дах салбар захирал

Нарийн бичгийн дарга: ХХҮГ-ын хөдөлмөр эрхлэлтийн хэлтсийн дарга

Хоёр. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд нийгмийн түншлэгч талуудын оролцоог ханган, орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн бодлого, үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, дүрмийн дагуу ажиллахыг зөвлөлийн дэд даргад үүрэг болгосугай.

Гурав. Уг захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2017 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн А/54 тоот захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА

О.БАТ-ЭРДЭНЭ

023000393